

2025 он 12 сар 18 өдөр

№ 25/28

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Албан тушаалаас чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76.1.8 дахь заалт, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Гүйцэтгэх захирлын албан тушаалаас Батбилэгийн Золбоо өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг хүлээн авч, 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь **ЧӨЛӨӨЛСҮГЭЙ**.
2. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах зорилгоор Гүйцэтгэх захирлыг томилох хүртэлх хугацаанд Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэх этгээдийг компанийн менежментийн багийн гишүүдээс сонгон ажиллуулах эрхийг ТУЗ-ийн дарга Ч.Ганхуягт **ОЛГОСУГАЙ**.
3. ТУЗ-ийн ЗНДЦУ хороо болон компанийн менежментийн багт Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, холбогдох журамд нийцүүлэн Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах үйл явцыг шуурхай явуулахыг **ДААЛГАСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025 он 12 сар 18 өдөр

№ 25/39

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18, компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 сарын 18-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал чөлөөлөгдсөнтэй холбоотой компанийн Гүйцэтгэх захирал томилогдох хүртэл хугацаанд компанийн банкууд дахь мөнгөн гүйлгээг зөвшөөрөх, батлах, удирдах эрхийг Санхүү эрхэлсэн захирал Г.Билгүүнд ОЛГОСУГАЙ.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудит эрхэлсэн захирал М.Мөнх-Эрдэнэд, холбогдох байгууллагуудад мэдээлэл хүргүүлж ажиллахыг ахлах нягтлан бодогч Б.Баасансүрэнд үүрэг БОЛГОСУГАЙ.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ